



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

ДАМПУУРЛЫН ХЭРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ НЬ МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР ТАТВАРЫН МЭДЭЭЛЭЛД ХАНДАХ ЭРХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: BVerwG 10 C 4.20

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 02 дугаар сарын 25 өдөр

Шийдвэрийн төлөв: Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

J. UG компанийн хөрөнгийг удирдахаар томилогдсон дампуурлын хэрэг гүйцэтгэгч нь өртэй этгээдийн хэлцлийг хүчингүйд тооцуулах эрхээ хэрэгжүүлэх зорилгоор татварын албанаас тус компанийн мэдээллийг гаргуулах тухай хүсэлт гаргажээ. Тодруулбал, татварын өрийг төлүүлэхээр албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах талаар анхааруулга хүргүүлж байсан эсэх, үүнтэй холбоотойгоор тухайн этгээд нь төлбөр төлж байсан эсэх талаар мэдээлэл гаргуулахыг хүссэн байна.

Харин татварын алба нь мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд мэдээлэл дамжуулахгүй байх үүрэгтэй тул нэхэмжлэгч буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзжээ. Иймд нэхэмжлэгч нь энэхүү татгалзлыг хууль бус гэж үзэн Кёльн хотын захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэгчийн хүссэн мэдээлэл нь нууц мэдээлэл боловч энэ нь Хойд Рейн-Вестфален мужийн Мэдээллийн эрх чөлөөний хуульд заасны дагуу дампуурлын хэрэг гүйцэтгэгчид хамаарахгүй тул холбогдох мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй гэж үзэн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна. Харин Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Холбооны Захиргааны хэргийн шүүхээс:

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсэг² заасны дагуу дампуурлын хэрэг гүйцэтгэгч нь **өр төлбөртэй этгээдийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах эрхтэй бөгөөд энэхүү эрхэд дампуурлын хэргийг шалгах зорилгоор холбогдох мэдээллийг олж авах эрх мөн хамаардаг. Харин татварын алба дампуурлын хэрэг гүйцэтгэгчид холбогдох мэдээллийг гаргаж өгөх нь татварын албыг татварын нууц хадгалах үүргээ зөрчсөн гэж үзэх**

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: <https://www.bverwg.de/en/250222U10C4.20.0> (Сүүлд үзсэн: 2026.02.11).

² Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль (1994)-ийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлмэгц өр төлбөртэй этгээдийн эд хөрөнгийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах эрх нь дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжинэ”.



үндэслэл болохгүй. Иймд **анхан болон давж заалдах шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх үед мөрдөгдөж байсан эрх зүйн зохицуулалтад үндэслэн** татварын алба нь дампуурлын хэрэг гүйцэтгэгчид мэдээлэл өгөх үүрэгтэй байсан гэж үзсэн.

Гэвч одоогийн Татварын хуулийн³ 32е зүйлд “Харьяалагдах этгээд эсвэл гуравдагч этгээд нь 2005 оны 9 дүгээр сарын 5-ны Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн (BGBl. I S. 2722) одоогийн хүчин төгөлдөр найруулга, эсвэл мужуудын түүнтэй адилтгах хуульд үндэслэн татварын байгууллагаас мэдээлэл авах эрхтэй бол, энэ тохиолдолд Европын Холбооны дүрмийн 2016/679 (EU) 12–15-р зүйлүүд ба §§ 32a–32d-тэй адилхан зохицуулалт үйлчилнэ. **Татварын мэдээллийн талаар нэмэлт мэдээлэл авах эрх энэ хүрээнд хүчингүй болно...**”, 32с зүйлийн 1 дэх хэсэгт “ЕХ-ны 2016/679 дугаар журмын 15 дугаар зүйлд заасны дагуу **татварын байгууллагаас мэдээлэл эзэмшигчийн мэдээлэл авах эрх нь дараах тохиолдолд үйлчлэхгүй:**” гээд 3 дах хэсэгт “**хувийн мэдээлэл**” гэж тус тус заасны дагуу **дампуурлын хэрэг гүйцэтгэгчийн мэдээлэлд хандах эрх нь хязгаарлагдаж байна.** Эдгээр хоёр заалтыг 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдөр хуульд нэмэлтээр оруулсан бөгөөд 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү нэмэлтээр оруулсан заалт нь Өгөгдөл хамгаалах ерөнхий зохицуулалтын⁴ 12-15 дугаар зүйлтэй хамт хэрэглэгддэг бөгөөд тус GDPR-ийн зохицуулалт нь хувийн мэдээллийг ашиглах тохиолдолд мэдээлэл эзэмшигчийн буюу мэдээллийн эзний оролцоог шаарддаг. Харин нэхэмжлэгч буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгч нь GDPR-ийн 12-15 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийн эзэн биш тул тухайн мэдээллийг шаардах эрхгүй байна гэжээ.

Дээрх нэмэлтээр оруулсан заалт нь мэдээллийн эзний эрхийг **шинээр тогтоож байгаа хэлбэр биш** бөгөөд өмнө байсан эрхийг Татварын хуулийн дагуу баталгаажуулж, гуравдагч этгээдийн мэдээлэлд хандах эрхэд хязгаарлалт тогтоосон зохицуулалт тул тус заалтыг хэрэглэх үндэслэлтэй хэмээн дүгнэсэн байна.

Иймд хариуцагчийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан хяналтын гомдол нь хууль зүйн үндэслэлтэй байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 137 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад нийцээгүй бөгөөд бусад үндэслэлээр ч зөвтгөгдөх боломжгүй тул тус шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

---o0o---

³ Abgabenordnung (1976), https://www.gesetze-im-internet.de/ao_1977/index.html (Сүүлд үзсэн: 2026.02.12).

⁴ General Data Protection Regulation (2016), <https://gdpr-info.eu/> (Сүүлд үзсэн: 2026.02.12).